■ ИЧИЖ АМЬДАР

"ШӨНИЙН ЗАХ"-ЫН ЭЗЭН М.ДАШДОНДОГ ТҮРЭЭСЛЭГЧДИЙГ ХОХИРООЖЭЭ

Түрүүч нь 1-р нүүрт

Тус захын удирдлагуудын хууд суртал, дээрэнгүй бүдүүлэг зан ааш нь тэвчихийн аргагүй хэцүү байдаг талаар тус захад лангуу түрээслэж байсан Н гэгч бүсгүй учирлаад, өнөөдрийг хүртэл лангууны барьцаа мөнгөө авч чадахгүй байгаа талаар доорх зүйлийг ярьсан юм. Тэрбээр "2014 оны арваннэгдүгээр сарын 22-ны өдөр тус захад 6.5 м2 лангуу түрээслэн ажиллах болсон юм. Уг лангуут түрээслэхийн тулд захын эзэн болох М.Дашдондогт түрээсийн барьцаа хэмээн хоёр сая төгрөгийг бэлнээр өгсөн юм. Гэтэл бидний түрээслэсэн хэсэгт ямар ч хүн орж ирэхгүй орлого байхгүй учир аргагүй эрхэнд өнгөрсөн нэгдүгээр сарын 16-ны өдөр М.Дашдондог захиралд өргөдөл гарган лангуугаа суллаж, барьцааны мөнгөө авъя гэж хэлсэн. Гэтэл захын удирдлагууд бидэнд одоо ямар ч мөнгө алга. Та нар ирэх долоодугаар сард мөнгөө ав гэж хэлсэн. Уг нь бидэнтэй анх гэрээ хийхдээ ийм хугацаагаар гэрээ хийгээгүй юм. Одоо нийтдээ тус захын удирдлагуудаас барьцаа мөнгөө авах гэсэн 40-50 хүн байна.

Уг нь М.Дашдондог захирал бидэнд хоёр сая төгрөг гаргаад өгчих боломжийн хүн гэдгийг хүн болгон мэднэ. Угаасаа түрээслэгчид гаргаа гэхэд араас нь барьцааны мөнгөө өгөөд орж байгаа өнөөгөөн олон түрээслэгчид байгаа. Гэтэл бид нарт мөнгө байхгүй долоодугаар сард ир гээд байна. Бид өнөөдөр амьдралаа залгуулах гэж энэ зах дээр лангуу түрээслэхээр ирсэн хүмүүс. Яг үнэндээ энэ хоёр сая төгрөгийг барьцаа мөнгө болгох өгөхийн тулд бусдаас хүүтэй зээлж зээсэн мөнгө шүү дээ. Тиймээс л бид барьцааны мөнгөө хурдан авмаар байна гэж явж ч хэлээд биднийг хүн гэж тоохгүй байна. Аргаа бараад хэвлэлд хандаж зохих газруудад нь гомдол гаргахаар зэхэж байна. Уг нь мөнгөтэй хүмүүст хоёр сая төгрөг гэдэг бол юу ч биш. Тэдний нэг оройных нь хоолны мөнгө байлгүй дээ. Хүн орохгүй байгаа газарт бид улам бүр түрээсийн өрөнд орж, өрөө дийлэхгүй болно шүү дээ. Түрээслэгчидтэй түйлын уян хатан харьцдаг гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр рекламддаг хүмүүс бодит байдал дээр шал өөр байдаг юм байна. Уг нь "Шөнийн зах"-ын эзэд нийгэмд налаад өндөр байр суурь эзэлсэн, төрийн алба хашдаг хүмүүс шүү дээ. Тухайлбал, захын эзэн М.Дашдондогийн төрсөн ах нь М.Хүрэлсүх гэж хүн бий. Энэ хүн өмнө нь тус захыг ажиллуулж байсан.

Одоо БОНХЯ-ны дэд сайд хийгээд, тарган цатгалан, өндөр албан тушаал хашиж явааа. Тэгэхээр өнөөдрийн эзэн М.Дашдондогийг мөнгө ихтэй, шинэ баячуудын нэгэн гэдгийг энэ захын хүчин



"Шөнийн зах"-ын эзэд барьцааны мөнгөө … иргэн Н-ийн гомдол

түрээслэгчид бүгдээрээ дуу нэгтэй батладаг. Гэтэл ийм баян, тарган хүмүүс ийм олон хүнийг түрээсийн барьцааны мөнгөөр хохироож болохгүй шүү дээ. Тиймээс М.Хүрэлсүх дэд сайд аа " Бид удахгүй хойдхоороо нахиж ярай ядан бор хоногийг өнгөрөөж яваа хүмүүс. Бид та нар шиг тарган цатгалан амьдардаг улс биш. Та бүхний халаасанд байгаа хоёр сая төгрөгийн хүүт төлөх нь бидэнд үнэхээр хүнд байна. Таныг энэ асуудалд анхаарлаа хандуулахыг хүсч байна" гэж хэлмээр байна" гэв. Ингээд мэдээллийг баттай болгохын тулд тус захын менежер Д.Хосбаярын 9595... дугаарын утас руу холбогдож бодит байдлын талаар хариулт авах гэсэн боловч тэрбээр утсаа авахгүй байсан юм.

Түүнчлэн эх сурвалж Н-ийн хэлж буйгаар анх хоёр сая төгрөгийн түрээсийн барьцаа мөнгө өгчихвөд одоо энэ бүрийн зүйл суутгасаар байгаад нэг сая найман зуун тавин мянган төгрөг авахаар болсон хэмээн ярьж байсан. Яг үнэндээ тэод ямар ч татвар төлдөггүй хүмүүсийг түрээслүүлэгчүүд гэж УИХ-ын гишүүн Г.Уянга хэлж байсан удаатай. Өөрөөр хэлбэл түрээслүүлэгчид сардаа хэдэн арван сая төгрөгийн ашгийг зовлонгүйгээр олдог гэсэн үг. Тэд ийм ч учраас түрээслэгчдийн эрх ашгийг дуртай үедээ зөрчих байдаг нэг бодит жишээ нь дээрх иргэний асуудал юм. Харин "Шөнийн зах"-ын эзэн М.Дашдондог өнгөрсөн онд өгсөн ярилцлагадаа их л боломжийн зүйл ярьж байх. Тэрбээр "Эрсдэлгүй зүйл гэж үгүй.

Би түрээслэгчиддээ санхүүгийн бэрхшээл, эрийн засгийн хямрал, борлуулалт эрс муудсан зэргийг харгалзан боломж олгодог" гэж ярьжээ. Гэтэл түүний хэлсэн энэ үг амьдрал дээр огт өөр байгаа нь түүнийг аль хэр ажил хэрэгч хүн бэ гэдгийг тодорхойлж буй юм. Ямартай ч тун удахгүй 40-50 хүн "Шөнийн зах"-ын хохирогчид хэмээн Чингисийн талбай дээр жагсаж, өлсөх байвал нэг их гайхах хэрэггүй бололтой. Юутай ч төрийн өндөр албан тушаал хашиж ард иргэдийнхээ ахуй амьдралыг хамгийн сайн мэдэж байх учиртай М.Хүрэлсүх дэд сайд аа, ядарсан иргэдэд хоёр сая төгрөг гэдэг тун их мөнгө.

Тиймээс таныг энэхүү асуудлыг анхааралдаа авч, хүмүүсийн хохирлыг яаралтай барагдуулна гэдэгт олон хүн итгэж байгааг үгээр уламжилъя. Мөн энэхүү асуудлыг ШӨХТГ-ынхан анхааралдаа авахад илүүдэхгүй бололтой.

■ ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

Шүүгчдийн тоог нэмэх шаардлагатай гэв

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчдийн ажлын ачааллын талаар мэдээлэл өгсөн юм. Тодруулбал, одоогийн байдлаар улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 341, давж заалдах шатны шүүхэд 109, хяналтын шатны шүүхэд 25 гээд нийт 475 шүүгч ажиллаж байгаа аж.

Тэдний хэлж буйгаар УИХ-ын тогтоолоор 718 шүүгчийн орон тоо баталсан ч одоо 33 хувийн орон тоо дутуу ажиллаж байна. Мөн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргийг шүүгчийн тоонд харьцуулан авч үзэхэд анхан шатны шүүхүүд нэг жилийн хугацаанд нийт 41558 хэрэг шийдвэрлэсэн нь нэг шүүгчид 121 хэрэг оногдож байгаа аж. Харин давж заалдах шатны шүүхэд гурван шүүгч нэг хэргийг шийдвэрлэдэг гэж үзэхээр нэг шүүгчид 137 хэрэг оногдож буй аж. Тус шүүхийн ОНХ хэлтсийн дарга П.Баабаа "Хяналтын шатны шүүх эрүүгийн 629, иргэний 1017, захиргааны 381 хэрэг шийдвэрлэжээ. Нэг хэргийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлөнө гэхээр нэг шүүгч 405 хэрэг дээр ажиллаж байна гэсэн үг юм. Мөн анхан шатны буюу дүүргийн, сум, сум дундын, захиргааны хэргийн анхан шатны шүүхээс гаргасан тогтоол захирамжийг авбал үзвэл нийт 137 492 тогтоол захирамж гаргаж. Ингэхээр нэг шүүгчид 403 тогтоол, захирамж оногдож байна. Энэ мэтчилэн шүүгчид маш их ачаалалтай ажиллаж байна. Шүүгчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай" гэдгийг онцолсон юм.

Хуульчдын мэргэжлийн хороонд 200 гаруй гомдол иржээ

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдаан энэ сарын 25, 26-нд боллоо.

Тус хуралдаанаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийн талаар иргэдээс ирүүлсэн гомдлыг хэлэлцэн шийдвэрлэсэн юм. Ингэхдээ нэр бүхий гурван хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүйгээр болон зургаан сар, хоёр жилээр тус тус хүчингүй болгож шийдвэрлэлээ. Эдгээр хуульч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22.6, 27.1, 27.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4.1.12, 1.7.1 зэргийг зөрчжээ. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийн талаар ирсэн гомдлыг Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын дагуу шалгаж шийдвэрлэдэг бөгөөд шийдвэрийг маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд оролцож буй бүрэлдэхүүн хэлэлцэн тогтоол гаргадаг байна.

Маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд оролцох бүрэлдэхүүнд Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн гурван шүүгч, нэг прокурор, нэг өмгөөлөгч багтдаг юм. Дашрамд дурьдахад, Мэргэжлийн хариуцлагын хороонд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилтэй холбоотой 200 гаруй гомдол ирсэн бөгөөд одоогоор хянан шалгах ажиллагаа явагдаж байгаа юм байна.

■ ҮЙЛ ЯВДАЛ

П.Ариунболд: Л.Эрхэмбаяр АН-ыг ирэх сонгуульд ялагдуулах гэж нууц гэрээ хийсэн

Хэвлэлийн хурлын үеэр 2015.03.02

Ардчилсан намын ЕНБД-ын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр нь Сонгинохайрхан дүүргийн АН-ыг өнгөрсөн 2012 оны Орон нутгийн сонгуулиар удирдан оролцож сонгуулийн үр дүнг улс төрийн гол өрсөлдөгч хүчин болох МАН-тай урьдчилан тохирч, СХД-ийн ИТХ, ЗДТГ-ын удирдах 34 албан тушаалаар наймаалцсан баримт бүхий "Маш нууц" гэрээ байгуулсан талаар СХД-ийн АН-ын хорооны гишүүн П.Ариунболд тэргүүтэй гишүүд өчигдөр хэвлэлийнхэнд мэдээлэл хийлээ.

Тэд хэлэхдээ "Иргэдийн сонголтыг улангаа гишгэсэн таван зүйл, хорин заалт бүхий энэхүү гэрээнд иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрх, намын үндсэн дүрэм, ардчиллын гол зарчим зэргийг зөрчсөн анхаарал татах нэлээн заалтууд байгааг нийтэд ил болгож буйгаа онцлон хэлсэн юм. Тодруулбал, уг гэрээнээс гол гэсэн зүйл заалтыг дурдвал, гэрээний Гуравдугаар зүйлийн Талуудын эрх үүргийг зохицуулсан хэсэгт "ИТХ, дүүргийн Засаг дарга, ЗДТГ, дэргэдэх хэлтэс, албадын удирдах бүрэлдэхүүнийг албан тушаалын томилгоог хоёр тал харилцан тохирч хавсралтаар батална". Энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын Нам, Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намууд нь харилцан эсрэг улс төрийн ажлыг зохион байгуулахгүй". "Хамтран ажиллах гэрээний хүрээнд тохирч томилсон албан тушаалтнуудаа хариуцлага тооцохгүй" зэрэг болно гэж нууцын зэрэглэлтэй гэрээ гэнэ. Тус дүүргийн АН-ын хорооны гишүүн П.Ариунболд "Л.Эрхэмбаяр нар "Маш нууц" гэж энэхүү гэрээг байгуулснаараа иргэдийн сонгох, сонгогдох эрх чөлөөнд ноцтой халдсан үйлдэл болж байна. Өнөөдрийг хүртэл СХД-ийн АН-аас ИТХ-д сонгогдсон Төлөөлөгчид нар гэдгийг Намын хорооны гишүүд ч мэдээгүй байгаа нь Л.Эрхэмбаяр АН болон өөр мэнгэ ... ...пишүүдээ ... дээр ... дүр зэрэг ... аваачин ... ирсэн.

Тиймээс энэхүү гэрээг гардан хийж, иргэдийн сонголт, намын үндсэн дүрмийг улангаа гишгэсэн Л.Эрхэмбаярт хариуцлага тооцох нь зүйтэй гэж үзэж хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандаж байгаа нь энэ гэв". Түүнчлэн түүний энэхүү хууль бус үйлдэл нь 2016 оны сонгуулиар АН-ыг ялагдуулах нэг үндэс суурь нь болох учраас түүнийг УЗХ-ны хурал дээр жинхэнэ томилохыг дэмжихгүй гэдгээ илэрхийлнэ гэж байсан юм.

olloo

"ОЛЛОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД

"Оллоо" ХК-ий Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурал
2015 оны 04-р сарын 27-ны өдрийн 16.00 цагт
Компаний байранд болно.

Бүртгэх өдөр 2015 оны 03-р сарын 13-ний өдөр
Хувьцаа эзэмшигчид та бүхэн 2015 оны 04-р сарын 13-аас харьяа БДК дээр ирж хурлын материалтай танилцана уу.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компаний 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компаний 2015 оны ажлын төлөвлөгөө
3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчилөн томилох асуудал
4. Компаний гэрчилгээнд өөрчлөлт хийх
5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх асуудал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Лавлах утас: 772-01100

БАРИМТ, ҮЙЛ ЯВДАЛ

Хулгай хийж байгаад эхнэр хүүхдээ орхиод зугтжээ

БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа монголчууд өнгөрсөн сард хоёр гамт хэрэгт холбогджээ. Тодруулбал, Канғнам дүүрэг дэх худалдааны гудамжинд байдаг бэлэн хувцасны дэлгүүрээс 40 шахам насны эрэгтэй, эмэгтэй хоёр хүн бага насны хүүхдээ дагуулаад хулгай хийсэн хэрэг өнгөрсөн сарын 15-нд гарчээ.

Сэжигтнүүд Монгол Улсын иргэн гэдгийг Канғнамын цагдаагийн байгууллагаас мэдээлжээ. Тэд хүүхдээ тэргэн дээр суулган брэнд хувцас зардаг дэлгүүрээс хэсэхдээ худалдагчдын сиймхийг ашиглан эмэгтэй цамц, пиджак, цүнх зэрэг үнэтэй бараа хулгайлж байжээ. Ингэхдээ хүүхдийнхээ тэрэгний доод хэсэгт тусгайлан бэлтгэсэн цүнх авч явдаг байсан аж. Тусгайлан бэлтгэсэн цүнх гадаг нь дотор талыг нь тугалган гадартай ааны дэвсгэрээр битүү бүрсэн байжээ. Ингэж бэлтгэсэн цүнхэнд байгаа барааг дохиоллын систем мэдэрдэггүйг ашиглан удаа дараа хулгай хийж байсан гэж цагдаагийн байгууллага үзжээ.

Тэднийг үйлдэл дээр нь барихад нөхөр нь эхнэр, хүүхэд хоёроо орхин зугтжээ. Цагдаагийн байгууллага хулгай хийж байсан монгол залууг эрэн сурвалжилж байгаа аж. Үүнтэй холбогдуулан Канғнам дүүрэгт хууль бусаар амьдарч байгаа монгол иргэдийг баривчлах нь их байгааг эх сурвалж мэдээллээ.

Дээрх хулгайн хэргээс гадна БНСУ-д амьдарч байсан манай улсын иргэн хоёр хүн зодуулжээ. Өнгөрсөн сарын 22-ны шөнө гудамжинд явж байсан хоёр солонгос иргэнийг манай улсын иргэн Б гэгч зодсон талаар Сувон хотын цагдаагийн газраас мэдээлжээ. Сэжигтэн Б оюутан солилцоогоор Солонгост суралцаж байсан аж. Тэрбээр Сувон хотын Ёнгдунгү дүүрэг дэх нэгэн гудамжинд явж байхдаа өөдөөсөө ирж байсан хоёр солонгос залуустай ярилцахыг завдсан байна. Залуучууд түүний асуултад хариулахгүй цааш эргэтэл зодуулсан тухайгаа мэдүүлжээ.

Сэжигтэн энэ тухай "Таньдаг хүмүүс байна гээд андуурч мэндэлсэн юм. Гэтэл юу ч ярихгүй болохоор нь зодсон" гэж мэдүүлжээ.

Дөрвөн настай охины уушги нь бяцарсны улмаас амиа алдсан бололтой

...хүчирхийлэлд байсан дөрвөн настай охин амиа алдсан нь нийгмийг цочроосон билээ. Охины амийг хөнөөсөн хэрэгт төрсөн эцэг, хойд эх хоёрыг нь сэжиглэн цагдан хориод байгаа. Талийгаачийн эцэг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд ...юм. Тиймээс уг хэрэг дээр ажиллаж байгаа шинжээч нараас "Ямархан нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй, хуулийн дагуу иогноз дүгнэлт гаргана. Хууль бус дүгнэлт гаргавал хуулийн хариуцлага хүлээнэ" гэсэн баталгааг цагдаагийн байгууллагаас гаргуулжээ. ...чөлөөлсөн аж. Шинжээчид охины уушгины бяцралт, тархины цус хуралтын улмаас амиа алдсан гэсэн дүгнэлт гаргасан бололтой. Энэ дүгнэлт нь охины гадны нөлөөтэй нас барсныг батлах аж.

Ц.ОРНОХ

"Эрдэнэс Таван толгойн" Я.Батсуурийн цагдан хорих хугацааг сунгажээ

"Эрдэнэс Таван толгой" компанийн гүйцэтгэх захирал Я.Батсуурийг Авлигатай тэмцэх газар баривчлан Цагдан хорих 461 дүгээр ангид саатуулсан билээ. Түүнийг 72 цагийн хугацаанд саатуулах зөвшөөрлийг АТГ-ынхан шүүхээс авсан юм. Я.Батсуурийг өнгөрсөн бутэн сайн өдөр суллах тухай мэдээлэл гарч байсан боловч үргэлжлүүлэн хорих шийдвэрийг Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны II шүүх гаргаж сэжигтнээр тооцсон байна. Сэжигтнээр тооцсон учир хоригдох хугацааг нь 14 хоногоор сунгажээ.

Я.Батсуурийг Эрүүгийн хуулийн 150.3-т заасныг буюу албан тушаалаа урвуулан ашиглаж улсад хохирол учруулсан хэрэгт сэжиглэж байгаа билээ.

Г.ОНОН

Орон сууцны зээлийн урьдчилгааны тал хувийг нийслэл даана

» Гурууч нь I нуурги

Учир нь зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн 30 хувь нь л орон сууцны урьдчилгаа төлбөрийг хийх чадвартай. Харин үлдсэн 70 хувь нь урт хугацааны зээл төлөх чадвартай боловч урьдчилгаа 30 хувийг төлөх чадваргүйгээс зээлд хамрагдаж чадахгүй байгаа юм. Гэтэл нийслэлд орон сууцны нийлүүлэлт эрс нэмэгдсэн боловч худалдан авалт буурч байгаа судалгааны хариу гарчээ. Энэ нь нийслэлээс хэрэгжүүлж байгаа Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлд саад учруулна. Ингэснээр дээд цэгтээ хүрээд байгаа утаа, хөрсний бохирдлоос салах хугацааг улам уртасгаж байгаа гэж үзжээ.

Өөрөөр хэлбэл утаа, хөрсний бохирдлыг бууруулах боломж нь орон сууц. Зээлээ төлөөд худалдан авах иргэд бэлэн. Дээрх санал хэрэгжвэл орон сууцны нийлүүлэлт ч нэмэгдэнэ. Гэтэл орон сууцны найман хувийн зээлийн урьдчилгаа төлбөр 30 хувь л иргэдийн орон сууцны зээлд хамрагдах боломжийг хааж байгаа аж. Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл энэ асуудлыг шийдэх гарц олсноо төсөл болгон НИТХ-ын даргад өнгөрөг бэрьж байна. Түүний үзэж буйгаар бол орон сууцны борлуулалтыг дэмжих зорилгоор "Улаанбаатар орон сууцны сан" байгуулна. Тэр сангаасаа иргэдийн орон сууцны зээлийн урьдчилгаа болох 30 хувийн төлбөрийн талыг төлж өгнө. Ингэснээр өнөөгийн борлогдохгүй байгаа барилгын борлуулалт нэмэгдэнэ. Орон сууцны борлуулалт нэмэгдэх тусам ...хэрэгцээ нэмэгдэнэ. Улмаар ажлын байр нэмэгдэж барилгын компаниуд байнгын ажиллагаатай болж, хүчирхэгжинэ. Барилгын компаниудын ашиг орлого нэмэгдэх тусам татаар төлөлт тэлж иргэдэд үзүүлсэн жаахан хөнгөлөлтөөс илүү хэрэгтэй төсөвт төвлөрөх боломжтой. Өөрөөр хэлбэл нийслэл гэр хорооллыг барилгажуулах ажлыг гацаагаад байгаа урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт иргэдэд үзүүлснээр утаа, хөрсний бохирдлоос салах ажлыг эрчимжүүлнэ. Одоохондоо орон сууцны борлуулалтыг өөр хэмд замаар дэмжих ямар ч гарц алга. Гэхдээ барилгын компаниуд хөл дээрээ босчихвол ажилтай, орлоготой иргэдтэй төрийн оролцоогүйгээр борлуулалтаа хийгээд байх нөхцөл бүрдэнэ. Нэгэн барилгын компанийн захирлын ярьж буйгаар бол төлбөрийн чадвартай иргэдтэй, дээр нь барилгын компаниуд капиталтай болсон тохиолдолд иргэдээс 30 хувийн урьдчилгаа авахгүйгээр түлхүүр гардуулах гэрээ хийж болно гэнэ. Өрхийн орлого 800 мянган төгрөг байхад л ... хамрагдах боломжтой. Гэтэл зуны цагт залуусыг өдрийн 25 мянган төгрөгийн цалинтай туслах ажилчин хийхийг уриад ирдэггүй гэнэ. Мэдээж байр нь бэлэн зээлийн шугам ойлгомжтой бол залуус өнөөдөр өдрийн 20 мянган төгрөгөөр ч ажиллах сонирхолтой болно. Харамсалтай нь зарим компаниуд ажлаа хийлгэчихээд цалингаа өгөхгүй гэх мэтийн асуудал тасрахгүй байна. Энэ бүхэнд төр оролцоод байх үндэс байхгүй. Харин түлхүүр гардаж аваад орон сууцанд орсон хүн маш хариуцлагатай болдог тухай засаг дарга Э.Бат-Үүл ярьж байна. Түүний найз нэг өдөр тамхинаас гарчихсан гэнэ. Учир нь тэрээр байрны лизинг төлж эхэлсэн аж. Гурван жилийн дараа буцаад тамхинд орсон гэнэ. Орон сууцныхаа зээлийг төлөөд дууссан учраас мань эр тамхи татаж эхэлсэн юм байх. Энэ жижиг жишээнээс харахад зээл хүнийг хариуцлагатай болгодог байж мэдэх юм. Гэхдээ өөрт нь тохирсон зээл хэн хэндээ өгөхөө өгнө. Хэрэв нийслэлийн ... НИТХ ... борлуулалт эрс нэмэгдэж утаа олон улсын өвгүүр орох биз ээ.

Х.БАТТӨГС

СУРГААТ

Ц.Амарбат багшийн компьютерийн програмчлалын Java My SQL, PHP андройд гар утасны програмчлалын практикт суурилсан 48 цагийн цогц сургалтанд бүртгэж байна. Төлбөр 300.000 төгрөг ☎ 99301979

Орос сургуулийн шалгалтанд хүүхэд бэлтгэнэ. Орос хэл гэрээр заана ☎ 99890767

Орос цэцэрлэг, есля хотын төвд ажиллаж байна. ☎ 99199001

Гадаад, Монгол багштай бүх хэлний 100% танцаарчилсан сургалт. Магистр төв. ☎ 99199001

Мандах бүртгэл дээд сургууль 3-р сарын 6-нд эхлэх жагтлан бодогчийн мэдлэг олгох дамжаанд бүртгэнэ. ☎ 70185949

3-р сарын 2, 3-нд эхлэх IBT TOEFL-ийн өдөр, оройн сургалтын ангид, 3-р сарын 28-нд, 4-р сарын 12, 18-нд явах албан ёсны IBT TOEFL-ийн шалгалт мөн 3-н сард авах албан ёсны GRE-ийн шалгалтанд түс түс бүртгэж байна. Study сургалтын төв ☎ 99115345, 314158

Санхүү эдийн засгийн дээд сургууль дээр нягтлан бодогчийн анхан шатны мэдлэг ... сургалтанд бүртгэж байна. ☎ 99192952, 99190510, 70157888

☎ 99049965, 318195

ХАМТРАН АЖИЛЛАХЫГ УРЬЖ БАЙНА

☎ 91130077

ТАЛБАЙ ХУДАЛДАНА

Хотын А зэрэглэлд байрлалтай "Peace tower" цамхагт Luxury зэрэглэлийн 22 мкв дээш оффисийн талбай худалдана.
Утас: 99105213, 99105215

ТАЛБАЙ ХУДАЛДАНА

Хотын А зэрэглэлд байрлалтай "Peace tower" Төвийн 6-р давхарт худалдаа үйлчилгээний чиглэлээр ажиллуулах боломжтой 77.75мкв талбайг хямд худалдана.
Утас: 99105213, 99105215

ОБЪЕКТ ХУДАЛДАНА

Хотын А бүсэд байрлах "Grand office" төвийн B1 давхарт 13 VIP өрөөтэй караокены чиглэлээр засвар хийгдсэн буй 680.57мкв объект худалдана.
Утас: 99105213, 99105215

Grindex

"Гриндекс" эмийн үйлдвэрийн Монгол дахь төлөөлөгчээр ажиллана.
Утас: 70075011, 88052239, 99136179

ACCOUNTING JOB

Australian invested company, Xanadu Wines LLC has excellent growth in its drinks business and has the following job vacancy:
Junior Accountant
Applicant should have the following qualifications:
> Bachelor's degree in Accounting
> Relevant work experience
> Computing skills including accounting software programs
> Good written and spoken English language and Mongolian
This is a challenging job and attracts a good salary

"ОЛЛОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД

"Оллоо" ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2015 оны 04-р сарын 27-ны өдрийн 16.00 цагт Компанийн байранд болно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙР

УРАН БҮТЭЭЛЧ

Монголын соёл яруу найргийн академийн тэргүүн, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Гомбожавын Мэнд-Ооёотой ярилцлаа.

Г.Мэнд-Ооёо: "Дэлхий ээж"-ийг маань мөнхийн дуу байна гэж хэлдэг

-Өнгөрөгч ням гарагт таны багш Бэгзийн Явуухулангийн төрсөн өдөр тохиолоо. Удахгүй мөн Дэлхийн яруу найргийн өдөр тохиох гэж байна. Утга зохиолтой айлсаж яваа хүний хувьд энэ өдрүүдийг хэрхэн хүлээж авдаг вэ?

-Монголын сод билэгт яруу найрагч Явуу багшийн маань төрсөн өдөр гуравдугаар сарын 15-ны өдөр болдог юм. 1982 оны хавар өдийд л багш маань тэнгэр дээшилж байлаа. Дараа жил нь буюу 1983 оны хавар бидний хэдэн шавь нар нь гуравдугаар сарын 15-ны өдөр багшийнхаа номын гэрт очиж гэргий Ж.Адъяа эгчтэй уулзаж гуравдугаар сарын 15-ныг "Явуугийн өдөр" гэж нэрлэхээр болсон юм. Тэндээс Алтан өлгийд очиж шарилынх нь дээр босгосон гэрэлт хөшөөний дэргэд шүлгүүдийг нь уншиж дурсан санаж байлаа. Түүнээс хойш жил бүр ямар нэгэн байдлаар Явуу багшийг дурсах үйл явдал болж эхэлсэн. Нэлээд хэдэн жилийн өмнө төрсөн өдрөөр нь Богд хан уулын оргил Цэцээ гүнд гарч "Хөх тэнгэрийн оройг ээгнэнхэн төрлөө би" гэдэг шүлгийнх нь мөрийг цагаан даавуун дээр монгол бичгээр бичиж уулын тэнгэрт мандуулж байсан нь одоо ч цээжинд тодхон байна. Тэр үед Явуугийн шилмэл 41 шүлэгтэй яруу найргийн номыг "Монгол шүлэг" гээд нэртэйгээр хэвлүүлээд авч явж байсан юм. Тэр номыг нь Цэцээ гүний оргилд хийморийн салхиар эрвэлзүүлсэн хэрэг л дээ. Энэ нь агуу яруу найрагчид хүндэтгэл үзүүлж буй үйл явдал гэж ойлгож болно. Өнөө жилийн хувьд нэг сайхан үйл явдал болсон нь яруу найрагч Д.Цоодол, Ж.Саруулбуян нар "Явуу багш" гээд сайхан ном [illegible] дурсамж эссэнээс бүрдсэн, уншиж бүрт ийм л хүн байсан даа гэж бодогдом сэтгэлийн утас зүгдсэн ном болсон байна лээ. Багшийн төрсөн өдрийн дараа буюу гуравдугаар сарын 21-нд Дэлхийн яруу найргийн өдөр тохиодог. Нэг талаараа Явуу багшийн өдөр ч юм шиг тийм л сайхан байдаг юм.

-Энгийн хүмүүс Явуухулан гуайг хүрч болохгүй оргил мэт хүлээж авдаг байсан. Гэтэл энэ эрхэм хүнтэй багш шавийн барилдлага тогтооно гэдэг мэдээж тэр бүр тохиогоод байх хувь тохиол биш гэж санагдах юм?

-1970-аад оны үед би чинь шүлэг яруу найрагт жинхэнэ хорхойтсон явлаа. Тэр үед Явуу багш Монголын зохиолчдын эвлэлд Яруу найргийн зөвлөлийн эрхлэгч, зохиолчдын эвлэлийн нарийн бичгийн даргын алба хашиж байв. Бид анхныхаа шүлэг зохиолыг бичиж өөрөөрөө нь их орж гарна. Явуу багш яруу найргийн клуб байгуулж, шүлэг яруу найрагт зүрх сэтгэлээрээ дурласан залуусаас сонголт хийгээд Зохиолчдын хороон дээр долоо хоног бүр цуглуулан, бидний шүлэг зохиолыг сонсоно. Явуу багш бидний шүлгийг сонсохоос гадна тухайн үеийн авъргууд С.Эрдэнэ, Д.Пүрэвдорж, М.Ширчинсүрэн, Д.Намаа, Ж.Шагдар гээд бүгд ярайтал суучихаад чих тавина шүү дээ. Бидний шүлгийг сонсчихоод зөвлөгөө өгнө. Зөвлөгөө өгөхдөө сацуу "бүт авна" гэж жигтэйхэн. Тэр бүгд л биднийг хүрцэлж байж дээ. Миний хувьд Их сургуулийг төгсөх үедээ анхныхаа шүлгийн түүврийг шигшүүлж байсан юм. Явуу багш өөрийн гараар тодорхойлолт бичиж анхны маань шүлгийн номыг өлгийдсөн. Түүний дараа Монголын зохиолчдын эвлэлд гишүүнээр элсэхэд мөн л тодорхойлолт бичиж Зохиолчдын эвлэл гэдэг айлын өндөр босгыг давуулж өгсөн юм даа. Бидний үеийн залуус Явуу [illegible] элсэсэн. Шүлэг найраг уншиж бие биенээ хүрцэлж явсан. Галзуу барын аманд тэрээ хиймээр залуу нас байлаа шүү дээ.

-Та яруу найргийн аль бүлгэмд хамаарч байсан юм бэ. Тухайн үед томоохон бүлгэмүүд яруу найрагт өөрчлөлт хийж байгаа шүү дээ?

-О.Дашбалбар, Д.Нямсүрэн, Л.Хүрэлбаатар, Ж.Саруулбуян, Ш.Гүрбазар, Я.Баатар, Ц.Ойдов, Д.Цогт, Ж.Оюунцэцэг гээд 10 залуу нэгдэж "Гал" гэж утга зохиолын бүлгэм байгуулсан. Тухайн үед жин тээж явсан хүмүүсийг гал хэмээн нэрлэдэг байсныг бодож манай галынхан гэдэг утгаар "Гал" хэмээн нэрийдэж байлаа. Галын дөл өндөр гээд их балгашээлтэй санагддаг байв. Тухайн үед байгууллага байгуулж болохгүй тул нууц бүлгэм маягаар явж, хүлээх тангарагтаа үнэнч явлаа. Бид бие биенээ дэмжин утга зохиолын ертөнцөд хамтдаа гарч ирнэ гэж бие биедээ андгайлсан юм. Өнөөдөр бол бүгд л утга зохиолд гарч ирж өөрсдийн мөрийг үлдээсэн. Эдэн дундаас хоёр агуу найрагч төрсөн нь О.Дашбалбар, Д.Нямсүрэн нар юм.

-Дэлхийн яруу найргийн өдрийг яагаад гуравдугаар сарын 21-ний өдөр тэмдэглэх болсон юм бэ. Манай улс хэзээнээс тэмдэглэж эхэлсэн юм бол?

-1999 оны арваадугаар сард ЮНЕСКО-гийн чуулганаас жил бүрийн гуравдугаар сарын 21-ний өдрийг Дэлхийн яруу найргийн өдөр болгон зарласан. ЮНЕСКО-гийн гишүүн орнууд, Засгийн газар, ТББ гээд бүхий л улс орнуудад яруу найргийг хөхиүлэн дэмжих уриалга гаргасан. Учир нь ЮНЕСКО хорьдугаар зууны төгсгөл үеийн сүүлийн 20 жилийн яруу найраг хийгээд утга зохиолд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр "Хориннэгдүгээр зуунд яруу найраг хүн төрөлхтний [illegible] Улс үндэстнүүд хоорондоо ойлголцож нэгтгэлцэх, хэл соёлоо хадгалж үлдэх, хүний дотоод сэтгэлийг ариусгах эрхэм зүйл нь яруу найраг юм" гэдгийг тунхагласан. Монгол Улс энэ уриалга гарсан цагаас хойш тэмдэглэж эхэлсэн. Өнөө жил гэхэд 15 дахь жилдээ тэмдэглэх гэж байна. ЮНЕСКО-гийн тунхагт "Яруу найраггүйгээр ямар ч үйлаг байхгүй" хэмээн иш татсан байдаг нь өөрөө гайхалтай агуулга бүхий юм.

-ЮНЕСКО-гоос дэлхийн улс орнуудад яруу найргийг түгээн дэлгэрүүлэх ёстой гэж байгаа хэдий ч манай оронд эсрэгээрээ байх шиг санагдах юм. Уран зохиолын хичээлийн цагийг нь хүртэл хаслаа гээд л. Өнөөдөр дуртай нэг нь холбосон хэдэн мөрөө шүлэг гэж өмөйтон ном хэвлүүлж ч байх шиг...

-Биднийг анхны номоо хэвлүүлж байхад үзэл суртлын асуудал байсан. Залуусын шүлэгт үзэл суртлын гаж нөлөө байх вий гэсэн болгоомжлол байв. Яруу найргийн урлалын хувьд маш хатуу шаардлага тавина. Ганцхан шүлэг тавихын тулд л олон шүүлтүүрээр ороод гарна. Ном гаргана гэдэг бүр хэцүү л дээ. Нэг талаасаа тийм цензур байсан нь зөв ч юм шиг. Одоо бол гарын сэлгээгээр юу гарна түүнийгээ бооцоод шидчихэж байна. Тэгэхээр уншигчид маш сайн шүүн тунгаах уншиж хэрэг болж байна. Нөгөө талаас утга зохиолын мэргэжлийн байгууллага үе үе үнэлэлт дүгнэлт өгдөг хэмжүүр дутагдаад байгаа юм уу даа. Утга зохиолын байгууллагад энэ байх ёстой.

-Дэлхийн яруу найргийн чиг хандлага аль зүг рүүгээ явж байна. Монголын яруу найргийн түвшинд аль зэрэгт яваа бол. Оюуны бүтээлийг хэмжих хэмжүүр байдаггүй хэдий ч судалгаа шинжилгээ хийдэг хүний хувьд хэрхэн хардаг вэ?

-Аливаа уран зохиолын хөгжлийн хандлага бол үргэлж хувирч өөрчлөгдөн шинэ зүйлийг хайсаар ирсэн. Сүүлийн үед миний оролцсон Дэлхийн яруу найргийн их хурлууд, олон улсын яруу найргийн наадмуудыг ажиж, тэр бүхэн дээр ирсэн хүмүүстэй танилцан ярилцаж байхад тэд "Изм" өрөөсөө ярьдаггүй. Харин зүрх сэтгэлээ яруу найргаар илэрхийлэх тухай л ярьдаг. Миний ойлголтоор аль ч улс үндэстний яруу найраг өөр нэг улс үндэстнүүдээс дутуу байна гэж байдаггүй. Харин өөр өөр [illegible] өөр улс оронд моод болсон.

-Яруу найргийг уралдуулж хэн нэгнийг шагнадаг улс дэлхий дээр байхгүй гэдэг. "Болор цом" ч юм уу бусад яруу найргийн наадмуудын тал дээр ямар байр суурьтай байдаг вэ?

-Яруу найргийн уралдаан гэхээсээ илүүтэйгээр яруу найргийн олон сайхан уншлагууд байх хэрэгтэй. Жишээлбэл, Японы эзэн хааны ивээлд жил бүр танка шүлгийн их том уншлага болдог. Тэнд мэргэжлийн яруу найрагчдаас гадна, эзэн хааны гэр бүлээс эхлээд бүгд оролцдог. Бүтэн жилийн турш шалгаруулж үлдсэн хүмүүсийг нь NHK телевизээр шууд дамжуулдаг. Түүнийг нь мэргэжлийн комисс шүүж шилдэг шүлэгт нь шагнал гардуулдаг. Эзэн хаан нь дараагийн жилийнхээ сэдвийг тэнд зарладаг байх жишээтэй. Энэ бол яруу найргийг хөхиүлж буй улс орны томоохон бодлого л доо. АНУ-ын ерөнхийлөгч гэхэд яруу найргийн зөвлөхтэй байдаг. Энэ ч гэсэн том бодлого шүү. Ерөнхийлөгчийн яруу найргийн зөвлөх нь улс орныхоо яруу найргийн ерөнхийлөгч байдаг гэхэд маш олон зүйлийг ярьж болно. Македонд гэхэд Струтгагийн яруу найргийн үдшүүд болдог. Улс орон даяараа энэхүү яруу найргийн уншлагыг хүлээн авч яруу найргаар амьсгалдаг. Ингэхийн тулд Засгийн газар нь жил бүр улсынхаа төсөвт мөнгө суулгаж байх жишээтэй. Энэ үеэрээ дэлхийн олон яруу найрагчдын бүтээлийг хэвлүүлэн гаргаж үндэснийхээ оюун санаанд шинэ үр суулгадаг. Өнгөрсөн жил гэхэд л засгийнхаа тэтгэлгээр миний яруу найргийн номыг Македон хэл дээр гаргалаа шүү дээ. Ноднин намар Румыний Крайова хотод Михай Эминескугийн яруу найргийн наадамд оролцсон. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдөж гэж үзэж байгаа өнөө цагийн 53 яруу найрагчийн 15 бүтээлийг франц хэл дээр аваад яруу найргийн том антологи хэвлэсэн байх жишээтэй. Дэлхийн улс үндэстнүүд зөвхөн өөрсдийн яруу найргаараа ариусан гэгээрэх төдийгүй үндэстний бахархал болгон дэлхий дахинд алдаршуулах гэж яруу найрагчаа хүлээн зөвшөөрүүлж, сонгодгийн хэмжээнд хүргэх зорилго тавьдаг юм билээ.

-Ноднин таны дээд шагнал авч шуугиан тариад байсан яруу найргийн наадам мөн биз дээ?

-Мөн л дээ. Үүнийг Европын Академиас зохион байгуулж байгаа боловч Азиас оролцуулсан нь сонирхолтой үйл явдал болсон. Бид ч гэсэн үндэсний яруу найргийн сонгодгуудаа дэлхий дахинд танилцуулах ёстой. Миний тэргүүлдэг Монголын Соёл яруу найргийн Академи жижигхэн байгууллага л даа. Гэхдээ "Монголын яруу найраг", "Монголын уран зохиолын дээж" гэх хоёр ч антологийг англи хэлнээ гаргалаа. Данзанравжаагийнхаа бүтээлийг англи хэл дээр орчуулан хоёр ч удаа гаргасан. Б.Явуухулан, О.Дашбалбар нарынхаа бүтээлийг англи [illegible] болгосон. Манай яруу найрагчдын бүтээлүүд бага багаар ч гэсэн хүмүүсийн анхаарлыг ертөнц эхэлсэн. Бид дэлхийн яруу найргийг дуудан бансахаас гадна өөрсдийн уран бүтээлүүдийг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй.

-Михай Эминескугийн яруу найргийн дээд шагнал хүртэхэд монголчууд маш өндрөөр хүлээж авсан ч төр засаг хэлс үнэртүүлсэн хэдэн бөхчүүдээсээ дорд үзэж байх шиг. Таныг энэ шагналыг хүртсэний дараа "Төрийн шагнал хүртээнэ" гэж маш их зарцгаасан...

-Оюунлаг ертөнцийг эрхэмлэдэг үйлдлүүд тэр засагт олон байгаасай гэж боддог. Энэ том шагнал шүү дээ. Нэг эгэл нүүдэлчин дэлхийн томчуудын урд гишгэсэн явдал чухал юм. Монголын яруу найргийн нэгэн төлөөлөл хориннэгдүгээр зуунд дэлхийд хүлээн зөвшөөрөгдөж 53 яруу найрагч оролцсон дэлхийн яруу найргийн наадмаас гранд буюу дээд шагналыг хүртэнэ гэдэг бол Монголын оюуны соёл тэдэнтэй эрсалдах хэмжээнд хүрчээ гэсэн дүгнэлт гарах болов уу.

Төрийн өндөрлөгүүдийн аль нэг нь хүлээн авч баяр хүргэх байх гэж хилээд ч хүлээсэн. Шоудах юм миний шагналд байхгүй болохоор нудаа аваад өнгөрсөн байх. Гэтэл тэр үед бусийк жижиг тэмцээнд оролцсон хүмүүст шагнал гардуулаад шоудаж л байгаа харагдсан. Оюуны хөдөлмөр материаллаг хөдөлмөрөөс өөр юм. Арай өөр түвшинийх юм шүү гэж хүлээж авах хэрэгтэй. Дэмждэг, хөхиүлдэг систем байх ёстой.

-Таны "Дэлхий ээж" дуу бол нэрийн хуудас тань болсон гэхэд болно. Өнөөдрийг хүртэл хичнээн дуу бүтээсэн бэ? "Дэлхий ээж" хэрхэн бүтэж байсан юм бол?

-"Дэлхий ээж" дуугаа би 27-28 настайдаа бичсэн. Тухайн үед улс төрийн дууны хамтлагууд бий болж байсан цаг. Тэгэхэд энхтайванаг дайн байлдааны эсрэг дууны уралдаан зарлахад би сэргэлдэх замаар биш эх дэлхийгээ хайрлах өнцгөөс бичвэл зүгээр юм уу л гэж бодсон. Р.Энхбаяр бид хоёр хамт ажиллаж байсан болохоор дорхноо дуу болж Б.Бадруугаан дуулж улс төрийн дууны уралдаанд тэргүүн байр эзэлж байсан юм. Тухайн үед хэлбэрийн хувьд шинэлэг болж чадсан. Өнөөдөр байгаль дэлхийгээ хайрлах үүднээс аваад үзэхэд цоо шинээрээ байгаа санагддаг юм. Манай зарим хүмүүс "Дэлхий ээж"-ийг маань мөнхийн дуу гэж хэлдэг. Яахав эд 20 гаруй настай залуу энэ зэрэгтэй хольж олж хэрж л байж дээ. Би 30 гаруй дуутай хүн дээ. Олны сайн мэдэх нь "Дэлхий ээж", "Ээжийн бүүвэйтэй хорвоо" юм даа.

-Таны яруу найргийг уншиж байхад нэг л тийм зөөлөн эйтэй мэдрэмж төрдөг. Та талын хүн болохоор ч юм уу шүлгийг тань уншихад уудам, цэлгэр [illegible]

-Миний яруу найргийг "зөөлөн эй" гэж томъёолоход дуртай байдаг. Байгалиас заяасан төрөлх зан чанартай холбоотой юм болов уу. Би чинь Дарьгангын хуурчийн хүү шүү дээ. Хар багаасаа хуурын аялгуу хөхөж өссөн гэхэд болно. Миний ээж сайхан үлгэрч хүн байлаа. Энэ бүхэн миний яруу найргийн хөг хэмнэлийг тогтоож өгсөн юм болов уу гэж боддог. Тэр үед томчууд намайг ирээдүй зүйл дутагдаж хэтэрхий зөөлөн байна хурц байх ёстой гэдэг байсан ч үнэхээр болдоггүй юм гэж болдоггүй юм байна лээ. Ингээд би өөрийнхөө замаар явж "Зөөлөн эй"-н эзэн болсон юм.

-"Шилийн богд" хэмээх шинэхэн романаа уншигч олондоо хүргэх гэж байгаа гэж дууллаа. Номынхоо талаар ярихгүй юу?

-"Гэгээнтэн" хэмээх романаа гаргасны дараа хүмүүс их маш сайхан хүлээн авч урмын үг их хайрласан. Тийм болохоор урам орсон гэж үү даа. Дарьгангын талаарх хориод жилийн судалгаа надад бий. Тэр утгаараа нэг сайхан бүтээл бий болгохсон гэж боддог байлаа. Тэр утгаараа "Шилийн богд" роман маань удахгүй хэвлэлтээс гарна тэр үед нь дэлгэрэнгүй ярилцъя.

Э.ЭНХБОЛД

"БАЯЛАГ НАЛАЙХ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Баялаг Налайх" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 15 цагт "Логос" төвийн байрны 403 тоотод болно.
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу "Логос" төв.
Бүртгэх хугацаа: 2015.03.27
Хурлаар хэлэлцэх асуудал:
а. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хараат бус аудитын хийсэн дүгнэлтийн талаар ТУЗ-ийн хийсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
б. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл болон 2015 оны зорилт батлах;
в. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
г. ТУЗ-ийн 2015 оны төсөв батлах;
д. Бусад.
Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөлтэй ажлын өдрүүдэд 900-1700 цагийн хооронд хурал хуралдуулах байранд байрлах ТУЗ-ийн даргаас эсхүл харилцагч брокер-дилерийн компаниуд дээрээс ирж танилцана уу.
Хурал зохион байгуулах комисс.
Утас: 99092451, 99030111

БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ЗАР

"Монкорд" ХЗХ-ны Бүх Гишүүдийн ээлжит Хурал 2015 оны 3-р сарын 21-ны Бямба гаригийн 10.30 цагт болно.
Хурлаар хэлэлцэх асуудал:
- 2014 оны тайлангууд, ашгийн хуваарилалт
- Тэргүүлэгчдийн зөвлөлийн ээлжит сонгууль
- Хяналтын зөвлөлийн ээлжит сонгууль

Хаана: БГД, Сант сургуулийн баруун талд, Вагон депогийн чанх ард талд Нарны зам дагуу байрлах **"АМБРОСИО"** рестораны танхимд болно.
Гишүүд та бүхэн хуралдаа идэвхитэй оролцоно уу.
www.monoord.mn- сайтнаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
Утас: 324460, 319539, 313699, 352405, 459173, 70003699

ollo

"ОЛЛОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД

"Оллоо" ХК-ий Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 27-ны өдрийн 16.00 цагт Компаний байранд болно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ОФФИС ТҮРЭЭСЛҮҮЛНЭ

"NEW HORIZONS"

Утас: 310050 /Ажлын цагаар/ 99443523

SR MOD INTERNATIONAL CO.,Ltd

Оросоос ирсэн модоор эко дүнзэн байшин, хаус барина

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, Express tower, 15 давхар 1505 тоот
SR mod international LLC
Утас: 91238722, 99998722

■ УИХ-ЫН ЭРГЭН ТОЙРОНД

О.Баасанхүү бужигнуулна

О.БААСАНХҮҮ УИХ-ын гишүүн

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны дарга О.Баасанхүү ажлаа тасалдаг, архи уудаг ангийнхаа нөхөдтэй найзархаад байхгүй гэдгээ зарлав. Иргэд, сонгогчдоос Өргөдлийн байнгын хороонд хандаж, хуралдаа суудаггүй, ажлаа тасалдаг, хийдүүлдэг гишүүдэд хариуцлага тооцох талаар санал хүсэлт олонтаа ирдэг болсон нь О.Баасанхүү даргыг ийнхүү зоригтой болгожээ. Түүний толгойлдог Өргөдлийн байнгын хороо УИХ-ын Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах хүрээнд чуулган, байнгын хороо, ажлын хэсгийн хуралдаанд оролцоогүй гишүүнийг, мөн дээрх хуралдаануудад согтуу ирсэн гишүүнийг эргүүлэн татах, хуралдаа нэг минут л хоцорвол 100 мянган төгрөгөөр торгох зэрэг заалттай чангахан хуулийн төсөл боловсруулж байгаагаа зарлав. Нийгэмд хүлээлт үүсгэсэн энэ хуулийн төслийг хаврын чуулганаар хэлэлцүүлнэ гэдгийг О.Баасанхүү даргын баруун гар, УИХ-ын гишүүн Ж.Батзандан мэдэгдсэн.

Үнэхээр ч УИХ-ын байнгын хороодын хуралдаан цагтаа эхэлж байсан түүх тун цөөхөн. Хэдийгээр "Тийм ээ би [illegible]

сүлжээний баатар болсон С.Дэмбэрэл зэрэг цөөн гишүүн ч байнгын хорооны хуралдаанд голдуу цагтаа ирчихсэн сууж харагддаг. Гэвч бусад нь цагтаа морилон ирдэггүй тул утсаараа оролдож, сонин гарчиглаж хэсэг суугаад тэсвэр алдан гараад явчихдаг. Харин УИХ-ын нэгдсэн чуулган найдвартай 30 минут хоцорч эхэлдэг. Энэ нь мөн л эрхэм гишүүдийн ирцтэй холбоотой байдаг.

УИХ-ын Өргөдлийн байнгын хороо нь намрын чуулганы хугацаанд найман удаа хуралдаж, 22 асуудал хэлэлцжээ. Үүнээс ес нь тус байнгын хорооноос гаргасан тогтоол гэнэ. Харин иргэд сонгогчдоос 1366 өргөдөл иржээ. Байнгын хороо байгуулагдсан цагаас хойш 3000 гаруй өргөдөл ирж, үүнээс 506 хүсэлтийг судлан шууд хариу өгсөн бол 272 хүсэлтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн гэв.

Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн анхаарал татах өргөдлийг голлож үзвэл, уул уурхайн салбарт газрын доор болон хүнд хортой нөхцөлд ажилласан иргэдэд нөхөн төлбөр олгогдохгүй байгаа тухай, "Эрдэнэс тавантолгой" ХХК-ийн 1072 хувьцааг буцаан эзэмшихийг хүссэн асуудлаар, тэтгэврийн зээлийн хүү өндөр байгааг судалж, хүүг бууруулах боломжийн талаар судлах зэрэг өргөн хүрээнд өргөдөл ирүүлжээ.

Чуулган завсарласан энэ хугацааг ашиглаж тус байнгын хороо тэтгэврийн зээлийн хүүг бууруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэж байгаа

■ ТҮҮХТ ӨДӨР

ТЭД ЭХ ОРНЫХОО ТӨЛӨӨ ТУЛАЛДСАН ЮМ

Түрүүч нь 1-р нүүрт

Зарим нь хорвоогийн жам, насны эрхээр өөрөө алхаж чадахгүй ... олж тулгандаа дээр суун эрхэм хүндтэй медалиа гардахаар ирсэн ч залуу цагийнх шигээ хэн нэгнийгээ хөөрхөн явуулж "Хүүе чи бүр улам залуужчихаж. Удахгүй танц эргэх нь холгүй байна" гэх ч юм уу "Нөгөө хэн маань яагаад ирсэнгүй вэ. Зүгээр л байгаа даа" гэцгээн өдрөөс өдөрт цөөрсөөр л байгаа дайны үеийн хамтдаа үнэрлэж явсан фронтын дайчин анд нөхрөө сураглацгаах нь бахархалтай хэрнээ гунигтай ...сан. Өнөөдөр Халх голын болон чөлөөлөх дайнд оролцсон 20 гаруйхан ахмад дайчин үлдсэн гэдгийг Дайнд оролцогсдын Монголын хорооны дарга, хошууч генерал Чимэдцэрэнгийн Самбуу гуай тэмдэглэн хэлэхдээ ээлхэн санаа алдаж байна лээ. Өнөөдөр Монголын ардын арми үүсэн байгуулагдсан түүхт 94 жилийн ойн баярын өдөр буюу Монгол цэргийн өдөр. Эр хүн болж сая 500 мянган хавтгай дөрвөлжин км газар нутаг дээрээ эрх чөлөөтэй амьдарч яваа хөх толбот Монгол эрчүүдийн баярын өдөр.

Ахмад дайчин хурандаа Д.Дэнзэн болон ОХУ-ын Элчин сайд Азизов Искандер Кубарович нар. 2015.03.18

Өнөөдөр 98 нас сүүдэр зэрэгцсэн Монгол Улсын баатар, ахмад дайчин П.Шагдарсүрэн, Москваг хамгаалан тулалдаж, Орос цэргүүдад цусаа өгч хөл дээр нь босгож явсан 93 настай ахмад дайчин, хурандаа Цэндийн Алтангэрэл, Сталинградын хамгаалалтад оролцон байлдаж явсан 95 настай ахмад дайчин, хурандаа Дагвын Дэнзэн гуай нарын баярын өдөр. Тэд хэний ч шахалт, шаардлагаар биш залуу насныхаа эр зориг, хүсэл тэмүүллээр сайн дураараа цэргийн албанд мордож Москва, Сталинград, Халх гол, Хамар даваа, Чуулалт хаалганд Германы фашизм, Японы милитаризмын эсрэг Монгол эх орон цаашлаад хүн төрөлхтнийг хамгаалан тулалдацгаасан юм. Тэд залуу ч явсан, хөвхаатай сайхан ч явцгаасан. Тэсрэх бөмбөг, улин исгэрэх сумны өөрөөс ухарч буцахгүй сөрөн зогсохдоо эр хүн шиг эрвэлзэж, эмээлтэй морьтойгоо дэрвэж явсан хиймортой, цог золбоотой залуу нас тэднийх. Өнөөдөр тэдний нүдний гал бөхөж, нүүрнийх нь арьс үрчлээтсэн ч халуун залуу зүрх сэтгэл нь хэвээ байсан 70 жилийн өмнөх шигээ оргилон, буцалсаар л явна. В.Путиний зарлигаар олгогдсон хүндтэй медалиа энгэртээ зүүлгэхдээ өмөлзөж зогссон энэ буурлууд 70 жилийн тэвчийсэн сайхан эрс явсан. Магадгүй дараа жилийн Монгол цэргийн өдөр дахин цуглахад хэн нэгнийх нь суудал онгойн эзгүйрч магадгүй ч эх орон ард түмнийхээ өмнө байгуулсан тэдний мөнхийн гавьяа хэзээ ч эзгүйрч алга болохгүй, үеийн үед дурсагдах гавьяатай. Тийм ээ өнөөдрийн энэ л бөгтийсөн жаахан өвгөд, эмгэд 70 жилийн өмнө эрслэн босч эх орныхоо төлөө тулалдсан юм. Хойч үе маань үеийн үед дурсан санах учиртай. Тэд эх орныхоо төлөө тулалдсан юм шүү.

■ АЙЛЧЛАЛ

УИХ-ын дарга "CeBIT-2015" үзэсгэлэн болон "Фольксваген" машины үйлдвэртэй танилцав

УИХ-ын дарга З.Энхболд мэдээллийн технологийн «CeBIT-2015» үзэсгэлэн үзэж байгаа нь. 2015.03.17

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд мэдээллийн технологийн "CeBIT-2015" үзэсгэлэнд тавигдсан мэдээллийн технологийн шинэ санаа, шилдэг бүтээлүүдтэй танилцав. "Германы үзэсгэлэн яармаг" ХК-ийн ТУЗ-ын гишүүн А.Грухов Улсын Их Хурлын даргыг угтан авч үзэсгэлэнг танилцуулжээ.

Дэлхийн 70 гаруй орны мэдээллийн технологийн тэргүүлэх компаниуд оролцож, тус салбарын шинэ техник, технологи, бүтээгдэхүүн, программ хангамж, инновацийн хандлагуудыг олон нийтэд танилцуулах "CeBIT-2015" үзэсгэлэн яармагийн нээлтэд ХБНГУ-ын Канцлер А.Меркель, БНХАУ-ын Ерөнхий Сайдын орлогч Ма Кай болон дэлхийн өндөр хэмжээний зочид оролцсон билээ.

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд "CeBIT-2015" үзэсгэлэнгийн үеэр шинэ технологийн шийдлийг танилцуулж буй E-Government хамгийн орчин үеийн технологийн шинэ санаа, Full ID Governance цахим үнэмлэхний хамгийн сүүлийн үеийн ухаалаг хувилбар, жижиг дунд бизнес эрхлэгч компаниудад санхүүгийн туслалцаа үйлчилгээ үзүүлдэг Datev public service-ийн үйл ажиллагаа, "Fraunhofer" компанийн "Smart rural areas" төсөл, ХБНГУ-ын хамгийн томд тооцогдох хөдөө аж ахуйн салбарын машин, механизм үйлдвэрлэгч CLAAS брендийн олон үйлдэлт трактор /мэдрэгчийн тусламжтайгаар мэдээлэл цуглуулдаг/ болон бусад шинэ бүтээгдэхүүнүүдтэй тус тус танилцав.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Доод Саксон муж улсын Ханновер хотноо жил бүр зохион байгуулагддаг үзэсгэлэн нь 1986 оноос хойш зохион байгуулагдаж ирсэн бөгөөд энэ удаа "CeBIT-2015" үзэсгэлэнд дэлхийн 70 гаруй орны 3300 гаруй компанийн төлөөлөл оролцож байгаа аж.

Үүний дараа УИХ-ын дарга Германы машин үйлдвэрлэгч Фольксвагены үйлдвэртэй танилцав. Тус үйлдвэр өдөрт 750 ширхэг Фольксваген Т-5 загварын микроавтобусыг үйлдвэрлэдэг бөгөөд тус машиныг хэрхэн үйлдвэрлэдэг тухай процессыг шат дамжлагаар бүрэн танилцуулжээ.

Энэхүү Фольксвагены микроавтобусыг нэг жилд ажлын 220 хоногт тасралтгүй үйлдвэрлэдэг юм байна. Фольксваген компани 1956 оноос Ханновер хотод үйлдвэрээ нээн ажиллуулж байгаа гэнэ. Тус үйлдвэр 14 мянган ажилтантай бөгөөд тэдгээрийн 11 хувь нь эмэгтэйчүүд байгаа гэсэн статистик үзүүлэлт байдаг аж. Үйлдвэрийн ажлын 85 хувь нь бүрэн автоматчлагдан, машин үйлдвэрлэх процессууд системчлэгджээ.

Дэлхийн хэдэн оронд өөрийн тусгай сүлжээ болон хэрэглэгчидтэй тус компанийн машины борлуулалт жилд 10 сая хүрдэг тооцоо байна. УИХ-ын дарга үйлдвэртэй танилцах үеэр УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Германы парламентын бүлгийн дарга Л.Болд, Монгол Улсаас Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ц.Болор болон албаны бусад хүмүүс байлцав.

ollo

"ОЛЛОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД

"Оллоо" ХК-ийн Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурал
2015 оны 04-р сарын 27-ны өдрийн 16.00 цагт
Компаний байранд болно.

Бүртгэх өдөр 2015 оны 03-р сарын 13-ний өдөр
Хувьцаа эзэмшигчид та бүхэн 2015 оны 04-р сарын 13-аас харьяа БДК дээр ирж хурлын материалтай танилцана уу.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн 2015 оны ажлын төлөвлөгөө
3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчлөн томилох асуудал
4. Компанийн гэрчилгээнд өөрчлөлт хийх
5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх асуудал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Лавлах утас: 772-01100